



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 494

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ДАРГА М.БАДАМСҮРЭН
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Дорнод аймгийн Монгол ардын нам"-ын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Дорнод аймгийн Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛОРТУУЛ

011020544

Дорнод аймгийн Монгол Ардын Намын
хорооны 2020 оны 04 дугаар сарын 22-ны
өдрийн ...р хуралдааны 11. тоот
тогтоолын хавсралт




**ДОРНОД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС
2020 ОНЫ АЙМАГ, СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Дорнод аймаг

Дорнод аймгийн Монгол Ардын намын хорооны Мөрийн хөтөлбөр нь:

Өмнөтгөл



1. Хүний хөгжлийн бодлого

- | | | |
|------|--|------|
| 1.1. | Орлоготой иргэн | - 11 |
| 1.2. | Эрүүл иргэн | - 23 |
| 1.3. | Боловсролтой иргэн | - 23 |
| 1.4. | Соёл урлагийн чиглэлээр | - 11 |
| 1.5. | Биеийн тамир, спортын чиглэлээр | - 13 |
| 1.6. | Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгаалал | - 12 |
| 1.7. | Залуучуудыг дэмжих чиглэлээр | - 10 |
| 1.8. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр | - 12 |
| 1.9. | Ахмад настны халамж, үйлчилгээний чиглэлээр | - 11 |

2. Эдийн засгийн бодлого

- | | | |
|------|---------------------------------------|------|
| 2.1. | Хүнс, Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд | - 28 |
| 2.2. | Аялал жуулчлалын бодлогын хүрээнд | - 15 |
| 2.3. | Хариуцлагатай уул уурхай | - 11 |

3. Ногоон хөгжил, хүний амьдрах орчны чанар хүртээмжийг сайжруулах бодлого

- | | | |
|------|---|------|
| 3.1. | Байгаль орчин | - 16 |
| 3.2. | Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн хүрээнд | - 15 |

4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар баримтлах бодлого - 19

- | | | |
|----|----------------------------------|-------|
| 5. | Чойбалсан хотын хөгжлийн бодлого | - 162 |
|----|----------------------------------|-------|

6. Орон нутгийн хөгжлийн бодлого - 14

- | | | |
|-------|------------------|------|
| 6.1. | Баяндун сум | - 13 |
| 6.2. | Баянтүмэн сум | - 13 |
| 6.3. | Баян-Уул сум | - 17 |
| 6.4. | Булган сум | - 8 |
| 6.5. | Гуванзагал сум | - 5 |
| 6.6. | Дашбалбар сум | - 7 |
| 6.7. | Сэргэлэн сум | - 9 |
| 6.8. | Матад сум | - 7 |
| 6.9. | Халхгол сум | - 14 |
| 6.10. | Хөлөнбуйр сум | - 9 |
| 6.11. | Цагаан-Овоо сум | - 12 |
| 6.12. | Чойбалсан сум | - 12 |
| 6.13. | Чулуунхороот сум | - 7 |

гэсэн үндсэн 6 бүлэг 539 зорилттой байна.

ӨМНӨТГӨЛ

2016 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар “Дорнод аймгийн 2016-2025 оны Хөгжлийн хөтөлбөр, 2030 он хүртэлх төсөөлөл” дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй болсон.

Аймгийн Өрсөлдөх чадварын ерөнхий үзүүлэлт 2019 онд 87,14 оноо болж 21 аймгаасаа 5 дугаарт эрэмблэгдлээ.

Дорнод аймаг нь Хүний хөгжлийн индексээрээ 2016 онд III байр, 2017,2018,2019 онд II байранд, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2000-2009 онд 14-18 дугаарт, 2014-2019 онд II байранд тус тус эрэмбэлэгдэж байна.

2017 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Сүхбаатарын одонгоор шагнагдаж, 2018 оны ажлаараа Монгол улсын “Шилдэг аймаг”-аар шалгарсан.

Аймгийн хүн амын дундаж наслалт 2016 оны эхэнд 68,69 жил байсан бол 2019 оны эцэст 69,69 жил болж өсөн, нийт халдварт өвчин 2016 онд 2578 /10000 хүн амд 337,1/ байсан бол 2019 онд 2045 /10000 хүн амд 252,5/ болж жилээс жилд тогтвортой буурсаар байна.

Аймгийн хэмжээнд нийт 37 цэцэрлэгт 7200 шахам хүүхэд хамрагдаж, ерөнхий боловсролын сургуульд 16,6 мянган хүүхэд суралцаж, ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчид их, дээд сургуульд элсэх элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоороо 2015-2018 онд улсдаа манлайлж, бага, дунд боловсролын сургалтын чанараараа 21 аймагтаа 1 дүгээрт эрэмбэлэгдлээ.

Аймгийн хэмжээнд мал сүрэг 5 төрөл дээр өсч 2,6 сая толгой малтай болж, 2015 онтой харьцуулахад 2019 оны байдлаар 52,6 хувиар, малчин өрхийн тоо 5318 болж 21,0 хувиар өслөө.

2016-2019 онд 33,4-42,2 мянган га талбайд тариалалт хийж, жилд 12,6-27,2 мянган тн ургац хураан авч, аймгийн нийт хүн амын гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг 100 хувиар хангасан байна. 2019 оны байдлаар 161.2 га-д төмс, 104.2 га-д хүнсний ногоо тариалж, нийт 2550,7 тн ургац хураан авч, хураан авсан ургацын хэмжээ 30,5 хувиар өсч, төмс, хүнсний ногооны хангамж 8,8 хувиар нэмэгдсэн байна.

Аймаг “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-тэй болж Дорнод аймагт ирсэн жуулчдын тоо 2016 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэж 4.8 тэрбум төгрөгийн орлогыг үйлчилгээний байгууллагад оруулсан байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт 33 жижиг үйлдвэр шинээр байгуулагдан, 413 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа өргөтгөж, 398 ажлын байр хадгалагдаж, 132 ажлын байр шинээр бий боллоо.

Уул уухайн компаниудтай хамтран ажиллах гэрээг байгуулж ажилласнаар 2019 онд аймгийн орон нутгийн хөгжлийн санд нийт 3.1 тэрбум төгрөг, 2020 онд 4.3 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлж байна.

Аймгийн татвар төлөгчдийн бааз нэмэгдэж 2016 онд бүртгэлтэй байсан 1735 татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо 2019 онд 2540 болж даруй 805-аар нэмэгдэж, нэмэгдсэн өртгийн албан татвараар улсын төсөвт төвлөрүүлэх орлого 2016 онтой харьцуулахад 62,6 хувиар өссөн байна.

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орлоготой иргэн

- 1.1.1. Өрхийн бичил бизнес болон жижиг дунд үйлдвэрийг зээл, төсөл, хөтөлбөрт нэн тэргүүнд хамруулах бодлого баримтална.
- 1.1.2. Жижиг дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, орон нутгийн зах зээлд нэн тэргүүнд хэрэгцээтэй салбар, чиглэлийн үйлдвэрлэлийг бага хүүтэй зээлд хамруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.4. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 1.1.5. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн орон нутгийн хэрэгцээнд тулгуурлан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулна.
- 1.1.6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.7. Ажил хайж буй иргэдэд шаардлагатай зөвлөгөө мэдээлэл, сургалт өгөх, мэдлэг, ур чадвар, хүсэл сонирхолд нь нийцсэн тохирох ажлын байранд зуучлах, ажил олгогчид шаардлагад нийцсэн албан хаагчийг олж өгөх, албан хаагчдыг чадваржуулах сургалтанд хамруулах зэрэг олон талт чиг үүрэг бүхий аймгийн төрийн болон хувийн “Хөдөлмөрийн бирж”-үүдийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.8. Аймгийн МСҮТ, Политехник коллеж, Дорнод Их сургууль нь Зүүн бүс нутаг, аймаг орон нутагт ажлын байрыг олноор нь нэмэгдүүлэх томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, хүний нөөцийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байраа өөрөө бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг нэмэгдүүлнэ.
- 1.1.9. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажил хайгчдыг чадавхжуулах, ажлын байранд нь дадлагажуулах, давтан сургахад хөдөлмөрийн бирж, мэргэжлийн холбоод, ажил олгогч эздийн холбоо, мэргэжлийн сургуулиудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.1.10. Аймгийн хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.1.11. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хуучин байрыг түшиглэн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулж гарааны бизнес эрхлэгчдийг үйлдвэрлэл, үйлчилгээний хямд түрээс бүхий байраар ханган бойжуулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нь өсгөнө.

1.2. Эрүүл иргэн

- 1.2.1. Аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр” (2017-2026 он)-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Өөрийгөө болон гэр бүл, хамт олноо аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор аймгийн нийт хүн амын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.2.3. Халхгол, Баян-Уул сумдад амжилттай хэрэгжиж байгаа “Анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг өргөжүүлэх нь” төслийг сумдын Эрүүл мэндийн төвүүдэд үе шаттай хэрэгжүүлж нутагшуулна.

- 1.2.4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангамжийг шинэчлэн сайжруулах замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.5. Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, эмнэлгийн мэдээллийг Улаанбаатар хотын эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.6. Эмч нарыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.7. Хеликобактертай тэмцэх, хянах хөтөлбөр хэрэгжүүлж, нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл, шарх, хорт хавдрын эсрэг "Хавдрын эсрэг хамтдаа" үндэсний хөтөлбөрийг аймагтаа хэрэгжүүлнэ.
- 1.2.8. "Эрүүл чийрэг-эр хүн" үндэсний хөтөлбөрийг аймагтаа хэрэгжүүлнэ.
- 1.2.9. Эмэгтэйчүүдийн товлот дархлаажуулалтыг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах "Эрүүл эмэгтэй" үндэсний хөтөлбөрийг аймагтаа хэрэгжүүлнэ.
- 1.2.10. Мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарыг хяналтад авч, Үндэсний төвд илгээж эмчлэх, сэтгэл зүйн засал хийх, урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хийнэ.
- 1.2.11. Өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.
- 1.2.12. Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр байгуулсан хүүхдийн амбулаторийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, хүүхдийн зүрх судас, мэдрэл, мэс засал, шүд, сэргээн засах чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.13. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл ялангуяа зүрх судасны эмгэгээс сэргийлэх, өвчлөл нас баралтыг бууруулах, харвалт, шигдээсийн төв байгуулах, ангиографийн оношилгоог нэвтрүүлэх зорилгоор Улсын 3 дугаар төв эмнэлэгтэй холбосон зайн оношилгоо, эмчилгээний нэгжийг аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд байгуулна.
- 1.2.14. Сумдын Эрүүл мэндийн төвүүдийг халаалтын нэгдсэн системд холбох ажлыг эхлүүлж, боловсон ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг үргэлжлүүлж, дуусгана.
- 1.2.15. Хүн амын дунд тархалт өндөртэй халдварт сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, чадамжийг сайжруулах зорилгоор сүрьеэгийн диспансерийн эмнэлэг болгон ажиллуулна.
- 1.2.16. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хүүхдийн хоолойн архаг(ангина) өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх "Эрүүл ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.17. Амны хөндийн өвчлөлөөс үүдэлтэй халдварт бус өвчнийг бууруулах ажлын хүрээнд хүүхэд олноороо хамрагддаг Ерөнхий боловсролын Хэрлэн сумын 1 дүгээр сургууль, "Шинэ хөгжил" цогцолбор сургуульд хүүхдийн шүдний кабинетыг байгуулж, ажиллах хүний нөөцөөр хангана.
- 1.2.18. Эмч, сувилагч, асрагч эмнэлгийн ажилтны нийгмийн асуудал, ажиллах орчинг сайжруулна.
- 1.2.19. Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтэн, сувилагч, албан хаагчдын ур чадвар, хүний нөөц, нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 1.2.20. Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чадавхыг сайжруулж, хавдар, зүрх судас, гэмтэл согог, эх нялхсын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, техник тоног төхөөрөмжийг сайжруулж, иргэд орон нутагтаа үндэсний түвшний тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.21. Хүүхдийн эмнэлгийг шинээр барина.
- 1.2.22. "Эхчүүдээ хайрлъя" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.23. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.

1.3. Боловсролтой иргэн

- 1.3.1. Аймгийн боловсролын чанар үндэсний хэмжээнд тэргүүлж байгаа амжилтаа бататган, үргэлжлүүлэх зорилгоор боловсролын салбарын хөгжлийг дэмжих “Эрдэм” (2021-2025 он) хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.2. Багш нар мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, харилцан суралцах, ахмад, залуу багш нарын залгамж холбоо, судлаач багш нарын хамтын ажиллагааг дэмжих “Багшийн хөгжлийн ордон”-той болно.
- 1.3.3. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан цэцэрлэгүүдийг шинээр барьж байгуулах, өргөтгөх ажлыг тасралтгүй хийж, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.3.4. Суралцагчдын сургууль, ангидаа суралцаж, хөгжих таатай орчин бүрдүүлэх “Манай анги” төслийг ерөнхий боловсролын сургуулиудад үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.5. “Сургууль, цэцэрлэгийн бүс” төслийг үргэлжлүүлэн сургууль, цэцэрлэгийн гадна хүүхдэд ээлтэй, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.3.6. Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, бага ангийн нэг багшид ноогдох хүүхдийн тоог цөөрүүлнэ.
- 1.3.7. Бага насны хүүхдүүд аав, ээжтэйгээ хамт байх, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор хөдөөгийн сумдад “Багийн бага сургууль” байгуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.8. Хүүхдүүдийг номоор дамжуулан танин мэдэхүйг нь хөгжүүлэх, хүмүүжүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэх үгийн баялаг, санал бодлоо илэрхийлэх, ярих чадварыг дэмжих зэрэг олон талт ач холбогдлыг нь нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулиудад жишиг номын сан байгуулах “Миний номын өргөө” төслийг дэмжиж ажиллана.
- 1.3.9. Аав, ээж, гэр бүлээсээ тусдаа Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн амьдардаг сургуулийн дотуур байрны барилгыг үе шаттайгаар шинэчилж, хүүхдийн сурч, амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.
- 1.3.10. Хүмүүсийн насан туршдаа тасралтгүй суралцах сургалт, танин мэдэхүйн эрэлт хэрэгцээнд суурилсан “Насан туршийн боловсрол” олгох үйл ажиллагааг сум бүрт чанаржуулна.
- 1.3.11. Олон улс, үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, судалгаа, инженерчлэл, инноваци, шинэ бүтээлийн патент зэрэг оюуны бүтээлийн үр ашгийг нь аймаг, орон нутагтаа нутагшуулж, түгээн дэлгэрүүлсэн байгууллага, иргэдийг дэмжиж, урамшуулна.
- 1.3.12. Багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, сайн туршлагаа нийт багш нартаа түгээн дэлгэрүүлэхийг нь дэмжиж, чадварлаг багшийн залгамж холбоог тасралтгүй үргэлжлүүлэх “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.13. Дорнод Их сургуулийг Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл бизнесийн төв болгон хөгжүүлэх зорилгоор “Дорнод аймаг дахь их сургуулиудын хотхон” байгуулахаар эхлүүлсэн ажлыг үе шаттай үргэлжлүүлнэ.
- 1.3.14. ОХУ, БНХАУ болон Зүүн Азийн орнуудтай оюутан солилцоо, соёл, хүмүүнлэгийн харилцаагаа өргөжүүлж, хамтран ажиллана.

- 1.3.15. Буйр нуурыг түшиглэн төр, хувийн хэвшлийн хамтын магадлан итгэмжлэгдсэн олон нийтийн оролцоотойгоор багш нарын зуны амралт сургалтын төв байгуулна.
- 1.3.16. Улирлын чанартай халдварт өвчний дэгдэлтийн үед цэцэрлэг, сургууль болон нийтийг хамарсан арга хэмжээний үед амны хаалт, гар ариутгагч, халуун хэмжигч хэрэглэхийг хэвшүүлнэ.
- 1.3.17. Өвлийн улиралд хүүхдийг ханиад, томуу, халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор ЕБС-ийн сурагчдын өвлийн амралтын хугацааг уртасгах, тодорхой цагт зохицуулалт хийх ажлыг мэргэжлийн байгууллагын санал, судалгаа дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэж байна.
- 1.3.18. ЕБС-д үдийн цай хөтөлбөрийг үргэлжлүүлж, үдийн хоолны үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлж, нэг хүүхдэд ногдох зардлыг 2 дахин нэмж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.
- 1.3.19. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих орчин бүрдүүлнэ.
- 1.3.20. Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлнэ.
- 1.3.21. Хувийн цэцэрлэг, сургуулийг ашгийн, ашгийн бус гэдгээс хамаарсан бодлого хэрэгжүүлж, ашгийн бус сургалтын байгууллагыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.22. Олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, судлаач, багийг дэмжиж урамшуулна.
- 1.3.23. Багш нарыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцанд хамруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4. Соёл, урлагийн чиглэлээр

- 1.4.1. Аймгийн "Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.4.2. "Эх хэл, эх түүх, өв соёл"-ыг хүүхэд, өсвөр үе, залууст өвлүүлэх зорилгоор төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгалыг таниулж, Алтаргана, Баргажин, Алтан дөрөө, Хатагин зэрэг үндэсний өв соёлын уламжлалт арга хэмжээг зохион байгуулна.
- 1.4.3. Соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.4.4. Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээх, биет өвийг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 1.4.5. Аймгийн "Музей"-н барилгын ажлыг дуусгаж, музей нь түүх, соёлын өвийн сургалт танин мэдэхүйн, аялал жуулчлалын төв байх зорилгоор шинэ музейн дотоод, гадаад тохижилтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.4.6. Монголын төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүх, үе үеийн эх орончдын байгуулсан гавъяаг ард түмэнд таниулах, цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн хайгуул судалгаа хийж, сурвалжлан олох, хадгалж хамгаалах, судлах, дэлгэн үзүүлэх, Монгол төрийн батлан хамгаалах бодлого шийдвэрийг сурталчлан таниулах зорилгоор аймгийн музейн хуучин барилгад "Цэргийн музей" байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 1.4.7. Аймаг, сумын төвөөс зайтай амьдардаг иргэд, гэр бүл, баг, жижиг суурин газарт нүүдлийн номын сан, соёлын багц үйлчилгээг хүргэхэд төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийг нэмэгдүүлнэ.
- 1.4.8. Халхгол сумын "Хүүхдийн овоо", Булган сумын Чингис хааны тахилгын байгууламж Тугийн сүм зэрэг түүхийн үнэ цэнэтэй газруудыг хамгаалах,

эрдэм шинжилгээ судалгааны ажлыг үргэлжлүүлэн, олон нийтэд таниулахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

1.4.9. Морин хуур, ерөөл магтаал, уртын дуу, бий биелгээ зэрэг үндэсний сонгодог урлагаар хичээллэдэг хүүхдүүдийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

1.4.10. Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

1.4.11. Халхгол суманд Ялалтын цогцолбор байгуулна.

1.5. Биеийн тамир, спортын чиглэлээр

1.5.1. Аймгийн "Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.2. Иргэд нийтээрээ биеийн тамир, спортоор хичээллэх, олон төрлийн секц, дугуйлан, сургалт, бялдаржуулалтын төвтэй, тамирчид бэлтгэл хийх, үзэгч, хөгжөөн дэмжигчтэй томоохон тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой, усан бассейн бүхий, биеийн тамир, спортын төвлөрсөн шинэ цогцолбортой болно.

1.5.3. Аймгийн төв наадмын талбайг иргэд нийтийн биеийн тамир, спортоор хичээллэж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг хөл бөмбөг, хөнгөн атлетик, гүйлт, дугуйн стандарт замтай, скейт, дугуйт тэшүүр зэргээр олноороо хичээллэх, тэмцээн зохион байгуулдаг, үзэгчдийн суудал нь сүүдрэвчтэй, тамирчдын хувцас солих өрөө, боловсон ариун цэврийн байгууламж бүхий байнгын үйл ажиллагаатай цогцолбор болгох зорилгоор үе шаттай шинэчлэн байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.5.4. Монголын үндэсний уламжлалт спорт, наадам, наадгайг хөгжүүлэх, өв соёлыг залуу үед түгээн дэлгэрүүлнэ. (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт)

1.5.5. Иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.6. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшил, төрийн бус байгууллага, спортын холбоо, клубуудын хамтын түншлэлийг нэмэгдүүлнэ.

1.5.7. Тэшүүр, шайбтай хоккей, цана зэрэг өвлийн спортоор хичээллэх тохь тухтай таатай орчныг нэмэгдүүлэх байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

1.5.8. Хөлбөмбөг, сагс, гар бөмбөг зэрэг хүүхэд залуусыг багийн спортоор олноор нь тогтмол, тогтвортой хичээллүүлж байгаа спортын клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.

1.5.9. Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, сум бүрд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.

1.5.10. Биеийн тамир, спортод хөрөнгө оруулалт хийсэн хувь хүн, аж ахуйн нэгжийг дэмжиж, олон нийтэд алдаршуулан сурталчилна.

1.5.11. Хэрлэн голын түшиглэн төр, хувийн хэвшлийн хамтын магадлан итгэмжлэгдсэн олон нийтийн оролцоотойгоор Тамирчдын бэлтгэл сургалт, дасгалжуулалтын дараах сэргэлтийн бааз байгуулна.

1.5.12. Иргэдийн эрүүл мэндэд тустай дасгал хөдөлгөөн, гүйлт, дугуй, фитнес, зэрэг нийтийн биеийн тамирын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй спорт клуб, хамтлагуудыг урамшуулан дэмжиж ажиллана.

1.5.13. Аймаг орон нутгийн нэрийн өмнөөс улс болон олон улсын тэмцээнд амжилттай оролцсон тамирчид дасгалжуулагчдыг амжилтаар нь урамшуулдаг урамшуулалын журам гаргаж хэрэгжүүлнэ.

1.6. Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгаалал

- 1.6.1. Өрх бүр угийн бичгээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ мэддэг үндэсний уламжлалыг шинэ гэр бүл бүрт өвлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.6.2. Хүн амын бүлгүүд, зорилтот өрхүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.
- 1.6.3. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах чиг үүргээр сум бүрт ажилладаг "Хамтарсан баг"-ийн чадавхыг бэхжүүлнэ.
- 1.6.4. Хүүхдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх клуб, дугуйлангууд, хүүхдийн үүсгэл санаачилгын байгууллагуудын нэгдсэн үйл ажиллагааг дэмждэг "Хүүхэд хөгжлийн ордон"-той болно.
- 1.6.5. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилийг дэмжихэд эцэг, эхчүүд, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.6. Магадлан итгэмжлэгдсэн спорт, чийрэгжүүлэлтийн төв байгуулна.
- 1.6.7. Сургуулийн хүүхдэд үйлчлэх эко автобусны тоог нэмэгдүүлнэ.
- 1.6.8. Хөгжих, хамгаалуулах, нийгмийн суурь үйлчилгээг хүүхэд нэг бүрт тэгш, хүртээмжтэй хүргэдэг "Хүүхдэд ээлтэй сум, байгууллага" болох хөдөлгөөнийг өрнүүлнэ.
- 1.6.9. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.
- 1.6.10. Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.6.11. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдэд нийгмийн хамгаалал, хууль эрх зүйн дэмжлэгт үйлчилгээ үзүүлдэг "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг төвлөрсөн дэд бүтцэд холбогдох байршилд шилжүүлнэ.
- 1.6.12. Байгууллага, аж ахуйн нэгжүүд дэргэдээ албан хаагчдынхаа хүүхдүүдийн хичээлийг давтуулах, хөгжүүлэх жижиг сургалтуудыг зохион байгуулах, нэгдсэн унаагаар цэцэрлэг, сургуульд нь хүргэж өгөх, авах зэрэг өдөр өнжүүлэх төвүүдийг байгуулахыг дэмжиж ажиллана.

1.7. Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.7.1. Аймгийн "Залуучуудын хөгжлийг дэмжих", "Оюутны хөгжил" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.7.2. Аймгийн хэмжээнд дутагдалтай, нэн шаардлагатай байгаа мэргэжлээр суралцаж буй оюутантай гэрээ байгуулж, орон нутагтаа ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 1.7.3. Оюутан, залуусын гадаад хэлний боловсролыг нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлнэ.
- 1.7.4. Асрамжийн газарт өсч, 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.7.5. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7.6. Залуу гэр бүл, хүүхэд, залуус шинээр иргэний үнэмлэхээ авах, иргэний андгай өргөх, гэр бүлээ батлуулах, шинэ хүүхдэд төрсний гэрчилгээ олгох зэрэг төрийн ёслол, хүндэтгэл үзүүлэх өргөөг сум бүрт Сумын Засаг даргын Тамгын газрыг түшиглэн байгуулна.
- 1.7.7. Залууст бизнесээ эхлэх, өргөтгөх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн "Start up" төвөөр дамжуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.7.8. Өсвөр үе, оюутан, залууст хөдөлмөрийн хүмүүжил, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалт дадлагын төвийг байгуулна.

- 1.7.9. Өсвөр үе, оюутан залуус, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 1.7.10. Гарааны бизнес эрхлэгч оюутан залууст бизнесээ тэлэх эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр

- 1.8.1. Олон улсын стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээг хангах, оролцоог сайжруулах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн сэргээн засах төв”-ийг шинээр байгуулна.
- 1.8.2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-д ажиллах хүний нөөцийг мэргэшүүлэн сургаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засах эмчилгээ, сувилгааны тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.8.3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-д хэл засал, хөдөлгөөн засал, ахуй засал, гэрээр очих үйлчилгээ үзүүлж, номын сан, компьютерийн хүртээмжийг сайжруулж, спортоор хичээллэх, хувь хүнийг хөгжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.
- 1.8.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд шаардлагатай туслах хэрэгслийн засвар, жижиг үйлдвэртэй болох ажлыг эхлүүлнэ.
- 1.8.5. Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх ажилд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.
- 1.8.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, насанд хүрэгчдийн суралцах орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүн, бүх шатны боловсрол эзэмших тэгш боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.8.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хувь хүний онцлогт нь тохирсон урт хугацааны зорилго, төлөвлөгөөтэй болж, суралцах, хөгжих, ажиллах сэтгэл зүй, мэргэжил, арга зүйгээр дэмжин туслах хөтөч үйлчилгээг (Life Coach-амьдралын дасгалжуулагч, чиглүүлэгч) шинээр хэрэгжүүлж эхэлнэ.
- 1.8.8. Ажил олгогч нарт төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагуудаас хамтарсан мэргэжил, арга зүйн зөвлөмжийг өгч, хамтран ажиллах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тохирсон тохируулгатай ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.8.9. Төрийн болон эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа, үйлчилгээ, мэдээлэл авах зэрэг үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэгш, хүртээмжтэй авах дэд бүтцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.8.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, спортын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
- 1.8.11. Аймгийн төв Чойбалсан хотод нийтийн тээврийн унаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд үнэ төлбөргүй үйлчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.8.12. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг сургалт мэдээллээр хангах зорилгоор дохионы хэлмэрч сургаж бэлтгэн ажиллуулна.

1.9. Ахмад настны халамж, үйлчилгээний чиглэлээр

- 1.9.1. “Ахмадын ачлал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аймаг, сумын Ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.9.2. Залуу үеийнхэнд ажлын туршлага, оюуны бүтээлээ өвлүүлэн үлдээх, эх оронч үзэл, уламжлалт ёс заншил, зан үйлийг төлөвшүүлэх ахмадуудын ажлыг дэмжиж ажиллана.

- 1.9.3. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.9.4. Аймгийн төвд болон сумдад ахмадуудын эрүүл мэндийг дэмжих өдрийн сувилалыг үргэлжлүүлэн ажиллуулна.
- 1.9.5. Аймаг, сумын Засаг дарга, агентлагууд дэргэдээ хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, үндэсний хөтөлбөрүүдийг, аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхэд зөвлөн туслах чиг үүрэг бүхий орон тооны бус ахмад ажилтан, мэргэжилтнүүдийн зөвлөх багтай байна.
- 1.9.6. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.9.7. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийг нь хамгаалах, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулах талаар идэвх санаачилгатай ажиллаж, байгууллага бүр "Ахмадын сан"-тай байх хуулийн хэрэгжилтийг хангана.
- 1.9.8. Асран халамжлагчгүй ахмад настныг асарч сувилдаг, Зүүн бүсийн ахмад настны асрамжийн газрын шинэ барилгын дотоод, гадаад орчны тохижилтын ажлыг хийнэ.
- 1.9.9. Аймгийн төв Чойбалсан хотод нийтийн тээврийн унаагаар ахмад настан үнэ төлбөргүй үйлчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.9.10. Ахмад настны санаачилгаар үүсгэн байгуулагдсан, нийт ажиллагсдын 50-иас доошгүй хувь нь ахмад настууд ажилладаг аж ахуйн нэгж, хоршоолол, нөхөрлөлийг буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлэнд нэн тэргүүнд хамруулан дэмжиж ажиллана.
- 1.9.11. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. Хүнс, Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд
- 2.1.1. Байгалийн нөхөн сэргээгдэх баялаг болох өвс тэжээл бэлтгэлийг нэмэгдүүлж, малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүнээ улс болон бүсийн улсын хэрэгцээнд нийлүүлэхээс гадна хил залгаа БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хянган, Хөлөнбуйр аймгуудад экспортолно.
- 2.1.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх үүднээс шош, эрдэнэшиш, наранцэцэг, вандуй, чихрийн манжин, эмийн ургамал, жимс жимсгэнэ зэрэг шинэ таримал ургамлыг тариалалах судалгаа хийж, тэдгээрт хөрөнгө оруулагчдыг татах, дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.3. Зөгийн аж ахуй эрхлэлтийг дэмжиж, цэвэр зөгийн балаар дотоодын хэрэгцээг хангаж, экспортолно.
- 2.1.4. Малын үүлдэр угсааг сайжруулж, фермерийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 2.1.5. Үр тариа, хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 2.1.6. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж нарийн ногоо боловсруулан савлах, талх, нарийн боовны цех болон гахай, тахианы аж ахуй хөгжүүлнэ.
- 2.1.7. Малчин, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдэх аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.1.8. Генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүнээс татгалзаж, хүнсний баталгаат байдлыг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж хяналтын тогтолцоог сайжруулна.
- 2.1.9. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын

- талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.1.10. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.1.11. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулах бэлтгэлийг хангаж, орон нутгийн менежментийг боловсронгуй болгоно.
- 2.1.12. Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөц газрын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.13. Газар тариалангийн үйлдвэрийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.1.14. Мал аж ахуйн эрүүл бүс бий болгох бодлого хэрэгжүүлнэ.
- 2.1.15. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэнэ.
- 2.1.16. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, жижиг дунд үйлдвэрлэл байгуулах ажлыг бодлогоор дэмжих, хөнгөлөлттэй зээлэнд хамруулахад дэмжинэ.
- 2.1.17. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортлох чиглэлээр гадаадын улс орнуудтай хамтран ажиллана.
- 2.1.18. Дорнод аймагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг хөрш орнуудад борлуулах гарц, сувгийг нээх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллана.
- 2.1.19. Аймгийн ИТХ-аас баталсан Бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.20. Хүнсний ногоо дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.21. Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлж өргөжүүлнэ.
- 2.1.22. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо-техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, хөдөө орон нутагт ажиллуулна.
- 2.1.23. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологийг дэмжинэ.
- 2.1.24. Хөрш орон, аймаг, хотуудтай худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.1.25. Монгол экспорт хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлж гадаад худалдааны нийт хэмжээг нэмэгдүүлэх замаар орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжих худалдааны бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.26. Импортыг орлох бараа бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, үйлдвэр үйлчилгээ эрхлэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл гарын үсгийн тоог цөөрүүлэх хугацааг уртасган давхардсан хяналт шалгалтыг арилгана.
- 2.1.27. Мал аж ахуйн талаар аймгийн ИТХ-аас гарсан шилжилт хөдөлгөөний журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.28. Жижиг, дундын үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжих зорилгоор жижиг дундын үйлдвэрлэлийн төв байгуулна.
- 2.2. Аялал жуулчлалын бодлогын хүрээнд
- 2.2.1. “Жуулчдад үйлчлэх мэдээллийн төв”-үүдийг Чойбалсан хот, хилийн боомтууд, Хөлөнбуйр сум зэрэг аяллын маршрутын дагуух газруудад байгуулж, дотоод, гадаадын жуулчдыг харилцаа холбоо, тээвэр, жуулчны бааз, аяллын маршрут, хөтөлбөр, газрын зураг зэрэг мэдээ, мэдээллээр хангана.
- 2.2.2. Эрээнцав, Хавирга боомтуудад хөрш орнуудын бизнес аяллыг хөгжүүлэх зорилгоор хил орчмын “аялал жуулчлалын чөлөөт бүс” байгуулах боломжийн талаар судалж, холбогдох талуудтай хамтран ажиллана.

- 2.2.3. Түүх, соёлын биет болон биет бус үзмэрүүдийг сэргээн засварлаж, сонирхолтой үзвэр үйлчилгээгээр өргөжүүлэн, жуулчинд үйлчлэх цэгүүдийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.2.4. Буйр нуурын зүүн эргийн амралтын бүс, Их бурхант цогцолбор, Халхголын Ялалт хөшөө, Ялалт музей зэрэг газарт өндөр хурдны интернэт нэвтрүүлнэ.
- 2.2.5. Хөрш орнуудын хил залгаа муж, аймгуудын аялал жуулчлалын газартай хамтран аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг чадавхжуулах нэгдсэн сургалт, дадлага, туршлага солилцох арга хэмжээг давтамжтайгаар зохион байгуулна.
- 2.2.6. Орон нутгийн онцлогт нийцсэн, байгаль орчинд ээлтэй, стандартын шаардлага хангасан, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалын бааз байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 2.2.7. Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.
- 2.2.8. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.2.9. Аялал жуулчлалын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.10. Байгаль, түүх, соёлын үзмэрийг сэргээн хамгаалах, зохистой ашиглах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.11. Аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн нэгдэх, хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.12. Аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын стандартын түвшинд хүргэх, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2.13. Ариун цэврийн байгууламжуудыг цогц байдлаар шийднэ.
- 2.2.14. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын байгаль орчинд ээлтэй стандартад нийцсэн эко ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.2.15. Аялал жуулчлалын бизнесийн таатай орчинг бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.3. Хариуцлагатай уул уурхай
- 2.3.1. Уул уурхайн лицензийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах талаар идэвхтэй ажиллана.
- 2.3.2. Уул уурхайн ашиглалтын талбай, тээвэрлэлтийн замыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, ашиглалтын технологийн зам барих ажлыг эхлүүлнэ.
- 2.3.3. Нөхөн сэргээлт хийдэг, дэвшилтэт техник технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласан төлбөрөө хугацаандаа төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 2.3.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн, хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Уул уурхай газрын тосны төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.
- 2.3.6. Уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг хүнсний болон ахуйн хэрэгцээний бараагаар хангах, туслан гүйцэтгүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.7. Уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэд малчдад малын өвс тэжээлийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлдэг байх зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
- 2.3.8. Аймгийн хэмжээнд бичил уул уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, шинээр бичил уул уурхай байгуулахыг дэмжихгүй.
- 2.3.9. Уул уурхайн нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

- 2.3.10. Уул уурхайд үйлдвэрийн технологид хэрэглэсэн усыг дахин ашиглах саарал ус нийлүүлэх төслийг дэмжинэ.
- 2.3.11. Оёмол бүтээгдэхүүн хувцас үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж орон нутгийн уул уурхайн болон ААН-үүдийн ажлын хувцасыг орон нутагтаа үйлдвэрлэж нийлүүлэхийг дэмжинэ.

3. НОГООН ХӨГЖИЛ, ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧНЫ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Байгаль орчин

- 3.1.1. Аймгийн хэмжээнд газрын нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мониторинг хийж үр дүнг сайжруулна.
- 3.1.2. Нутгийн иргэдийн санал, хяналтад тулгуурлан, тарваганы тархац нутгийг нэмэгдүүлж, сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулж, Их Хянганы нурууны элбэг тоотой бусад хөхтөн амьтдаас тусгай хамгаалалттай бусад газруудад нутагшуулах асуудлыг судлаж зохион байгуулна.
- 3.1.3. Ой, хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шороон зурвас байгуулан, намар, хаврын улиралд сэргээн сайжруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 3.1.4. Ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэн, ойжуулсан талбайг арчилж, тордох, хамгаалах ажлыг сайжруулна.
- 3.1.5. Ногоон орчинг бүрдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг байнгын, өрсөлдөөнт, сайн дурын хэлбэрээр өрнүүлнэ.
- 3.1.6. Буйр нуурын эрэг орчмын элсний нүүдлийг зогсоох, цөлжилтийг сааруулах ажил зохион байгуулна.
- 3.1.7. Цас борооны ус хуримтлуулж хөв цөөрөм байгуулах газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- 3.1.8. Улз голын урсацыг нэмэгдүүлэх Онон-Улз төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.1.9. Булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 3.1.10. "Нэг голын хүүхдүүд" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.1.11. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.1.12. Аймгийн нүүрсний ордуудыг түшиглэн шахмал түлшний үйлдвэр барих ажлыг эхлүүлж, агаарын бохирдлыг бууруулна.
- 3.1.13. Орон нутгийн өмчит "Байгаль хамгаалалтын захиргаа"-ны байгууллагыг ажиллах нөхцөлөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.14. "Ногоон хэрэм" төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.
- 3.1.15. Зориудаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийнэ.
- 3.1.16. Сав баглаа боодлын үйлдвэр байгуулна.

3.2. Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн хүрээнд

- 3.2.1. Сумын төв болон Чойбалсан хотын захын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам татах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.2. Аймгийн төвтэй хамгийн ойр байрлах хилийн боомт хүртэл буюу Чойбалсан хотоос Хавирга хилийн боомт хүртэл 124 км хатуу хучилттай авто зам барина.

- 3.2.3. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн үргэлжлэл болгон Чойбалсан хотоос Мэнэн хүртэл 160 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ.
- 3.2.4. Баянхошуу, Хавирга, Эрэнцавын хилийн боомтуудын хүчин чадлыг өргөтгөж, ачаа болон зорчигч тээврийн нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулна.
- 3.2.5. Хүнд даацын ачааны машинуудаас болж, авто зам эвдэрч байгаад дүгнэлт хийж, баригдаж буй замын чанар, ашиглалт, хүнд даацын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, тээврийн хэрэгслийн даацыг хэмжих тоног төхөөрөмжийг улсын чанартай авто замд суурилуулах талаар санаачлагатай ажиллана.
- 3.2.6. Халхгол, Баяндун суманд байгуулах нисэх онгоцны буудлыг тохижуулж, энэ чиглэлд нислэг үйлдэх боломж бүрдүүлнэ.
- 3.2.7. Хөлөнбуйр сумын нутаг Чойбалсан-Улаанбаатар чиглэлийн 123-ын түр буудаллах авто зогсоолыг зорчигч, жуулчдад зориулсан орчин үеийн тохижилттой болгох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.8. Чулуунхороот, Халхгол, Дашбалбар сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбосноор бүх сумдын айл өрх, албан байгууллагууд интернэт үйлчилгээгээр хангагдана.
- 3.2.9. "ДБЭХС" ТӨХК-ийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт болгон өргөтгөж, дотоодын эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 3.2.10. Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Зүүн бүсийн тулгуур төв-Чойбалсан хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх хүрээнд хэсэгчилсэн барилгажилтын дахин төлөвлөлт хийх зураг төсөл, ажлын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг зохион байгуулна.
- 3.2.11. Аймаг, сумын төвийн явган хүний зам, дугуйн замыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, стандартад нийцсэн зам тавина.
- 3.2.12. Хилийн боомтууд, уул уурхайн суурин, аялал жуулчлалын баазуудад орчин үеийн стандартад нийцсэн нийтийн бие засах газар, халуун усны газартай болох зэрэг ариун цэврийн суурь үйлчилгээг хангах шаардлага тавьж, хэрэгжилтийг үе шаттайгаар хангуулна.
- 3.2.13. Гэрэлтүүлэг, камер бүхий авто зогсоолыг орон сууцны хорооллын байшингийн ар талд болон боломжтой газарт газар доорхи авто зогсоол байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 3.2.14. Баянтүмэн авто замын ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.2.15. Орон сууцны төлөвлөлтөд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.

4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

- 4.1. Төрийн бүх шатны байгууллагуудын боловсон хүчний чадавхыг сайжруулж, туршлагатай ахмад мэргэжилтэн, зөвлөхүүдийн туршлагаас дунд болон залуу үедээ хуваалцах, зөвлөгөө өгөх боломжийг бий болгоно.
- 4.2. Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх ажлыг цахим e-office хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэж, төрийн үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.3. Төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.4. Сум, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудтай гэрээ байгуулж, орон нутагтаа ажиллах бололцоог хангана.

- 4.5. Албан хаагчдын ажлын байрны чиг үүргийг ил тод болгон үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээнд тулгуурлан үнэлж, ёс зүй – хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- 4.6. “Төрийн албан хаагчийн сургалт хөгжил нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 4.7. “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.8. Төрийн албан хаагчийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.9. Иргэдэд шууд үйлчилгээ хүргэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадварт иргэд үнэлгээ өгөх нэгдсэн системийг нэвтрүүлнэ.
- 4.10. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд хөндлөнгийн мониторинг хийж, үйл ажиллагааг нь сайжруулахад мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 4.11. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог — сайжруулах, мэргэжилтнүүдийн ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцуулах зорилгоор сургалт зохион байгуулна.
- 4.12. Цахим аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлнэ.
- 4.13. Аймгийн өрсөлдөх чадварын амжилтыг бататгах, цаашид тогтвортой өсгөх, шалгуур үзүүлэлтүүдийн эзлэх эрэмбийг ахиулна.
- 4.14. Сумдын хөгжлийн цогц суурь судалгаатай болох зорилгоор сумдын өрсөлдөх чадварыг хоёр жил тутамд тодорхойлдог болно.
- 4.15. Аймаг, орон нутагт жендэрийн мэдрэмжтэй бодлогын бичиг баримтыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээнд жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, шинжилгээг нэвтрүүлж эхэлнэ.
- 4.16. Хөрш орнуудын хил залгаа болон зүүн хойд бүс нутгийн муж, хотуудтай санамж бичгийн хүрээнд нийгэм, эдийн засгийн салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлнэ.
- 4.17. Олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, амжилттай үр дүн, үр нөлөө бүхий олон улсын төслүүдийг нутагшуулна.
- 4.18. “Их Түмэн санаачилга”-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, гишүүн орнуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, үр ашигтай хамтран ажиллана.
- 4.19. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдийн сэтгэл ханамжийг судлах ажлыг мэргэжлийн судалгааны баг, төр, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн үр дүнг тооцож ажиллана.

5. ЧОЙБАЛСАН ХОТЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1.1. Хүүхдийн шүд цоорох өвчлөлийг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг үргэлжлүүлж, боловсролын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.
- 5.1.2. Хэрлэн сумын “Ягаан цээнэ” өрхийн эмнэлгийн төвийн салбарын барилгыг өргөтгөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, иргэдэд үйлчлэх уламжлалт эмчилгээ сувилгаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.3. Хэрлэн сумын 2, 3 дугаар багт өрхийн эмнэлгийн салбар шинээр барьж, эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулна.
- 5.1.4. Сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах зорилгоор судалгаа, тооцоонд үндэслэн шинээр цэцэрлэг байгуулах, өргөтгөх ажлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэнэ.
- 5.1.5. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 5.1.6. Хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

- 5.1.7. Хотын иргэдийг мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.
- 5.1.8. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, бага, дунд оврын зoorь агуулах барихад зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлж, үр тариа, төмс хүнсний ногоо тариалах газрыг хуулийн хүрээнд давуу эрхээр эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.1.9. Мал аж ахуйн гаралтай түүхий эд (арьс шир, ноос), газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээлийн болон санхүүгийн бусад дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.10. Стандартын шаардлагад нийцсэн мал нядалгааны төвийг байгуулж, орчны эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг хангаж ажиллана.
- 5.1.11. Чойбалсан хотын алслагдсан гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.1.12. Гэр хорооллын айл өрхүүдийг цагийн ялгавартай тарифт шилжүүлэх замаар дулааны хэрэгцээгээ хангаж байгаа өрхийн шөнийн цахилгааныг хөнгөлөх, чөлөөлөхөд дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.13. Чойбалсан нисэх буудлыг олон улсын 4C зэрэглэл бүхий зорчигч үйлчилгээний цогцолбор болгон шинэчилнэ.
- 5.1.14. Чойбалсан хотын босоо, хэвтээ тэнхлэгийн авто замыг хатуу хучилттай болгох, автомашины зогсоол байгуулах, туслах замыг өргөтгөх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.1.15. Авто зам, замын байгууламжийн шинэчлэл, засвар, арчлалт, тэмдэгжүүлэлтийг хариуцсан төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.16. Хэрлэн голын модон гүүрийг төмөр бетон гүүр болгон шинээр тавина.
- 5.1.17. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чойбалсан хотод сайжруулсан түлшний үйлдвэрийг байгуулж агаарын бохирдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.
- 5.1.18. Чойбалсан хотын усан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор гүний нөөц худгийг нэмэгдүүлнэ.
- 5.1.19. Чойбалсан хотын бохир усны шугамуудыг шинэчлэн сайжруулах ажлыг эхлүүлнэ.
- 5.1.20. Чойбалсан хотын ундны усны эх үүсвэрийн цуглуулах шугамыг шинэчилж хотын ундны усны найдвартай байдлыг хангана.
- 5.1.21. Чойбалсан хотын нийтийн эзэмшлийн орон сууцны байруудын халуун хүйтэн усны болон халаалтын шугамыг шат дараатайгаар шинэчлэн засварлана.
- 5.1.22. Чойбалсан хотын гэр хорооллын үерийн ус зайлуулах болон цуглуулах байгууламж /үерийн ус зайлуулах суваг шуудуу/-ийг барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.1.23. Хэрлэн сумын I, VIII багт бага оврын цэвэрлэх байгууламжийг байгуулж орчны бохирдлоос сэргийлнэ.
- 5.1.24. Хэрлэн сумын гэр хороололд халуун усны газрын хүрэлцээг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.1.25. Хэрлэн сумын гэр хорооллын алслагдсан хэсэгт зөөврийн усан сан, гүний худгийг нэмэгдүүлнэ.
- 5.1.26. Чойбалсан хотод хог хаягдал боловсруулах үйлдвэр барина.
- 5.1.27. Аймгийн төвийн хог хаягдал булах төвлөрсөн цэгийг нүүлгэн шилжүүлж, хот орчны бохирдол үүсэхгүй байхаар тохижуулж, мод тарьж, хашаажуулна.
- 5.1.28. Хотын төв болон гэр хороололд явган хүний болон дугуйн замыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй стандартад нийцсэн зам тавина.
- 5.1.29. Иргэдийн аюулгүй, тайван амьдрах орчныг бүрдүүлэх үүднээс хотын гудамж, зам, талбай, олон нийтийн зорчих хэсэг, гэр хорооллын гудамжийг үе шаттайгаар бүрэн камержуулах, гэрэлтүүлэгтэй болгох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- 5.1.30. Чойбалсан хотын тохижилт, хог хаягдлын асуудлыг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжиж буй "Цэмцгэр Чойбалсан" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.1.31. Чойбалсан хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, хашаа гудамжийг жигдрүүлэх, нэг стандарттай болгох, орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.
- 5.1.32. Чойбалсан хотын нийтийн орон сууцны байшингуудын дээврийг засварлах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, байруудын гадна фасадыг шинэчлэн сэргээж засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.1.33. Гэр хорооллын багуудад "Гудамж" төслийг хэрэгжүүлж, иргэдийг эрүүл цэвэр, аюулгүй орчинд амьдрах боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.34. Хэрлэн сумын 3 дугаар багт одоо баригдаж буй 640 хүүхдийн сургууль, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг бүрэн дуусгаж нийгэм, соёлын үйлчилгээ бүхий 1000 айлын орон сууцны хороолол байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.1.35. Агаарын бохирдлыг багасгах зорилгоор гэр хорооллын айлуудыг сайжруулсан түлш, утаа бага ялгаруулдаг зуух, дулаан баригч, цахилгааны хэмнэлттэй халаагуур ашиглахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.36. "Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-т менежментийн шинэчлэл хийж, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 5.1.37. Хотын төв болон гэр хороололд стандартын шаардлага хангасан тоглоом, чийрэгжүүлэлтийн талбайнуудыг шинээр байгуулж хүрэлцээг нэмэгдүүлнэ.
- 5.1.38. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээг иргэнд хүрч үйлчлэх боломжоор хангахад машин техник, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.39. Махны захыг стандартын шаардлага хангасан болгоно.
- 5.1.40. Хүнсний ногооны тариалалтыг дэмжих зорилгоор гэр хороололд гүний худаг, усалгааны шугам татах ажлыг эхлүүлнэ.
- 5.1.41. Иргэд олноор зорчдог нийтийн эзэмшлийн гудамж, талбайд боловсон ариун цэврийн байгууламж барина.
- 5.1.42. Тусгаар тогтнолын талбай, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн, Найрамдал парк орчныг бичил цэцэрлэгээр сэргээн тохижуулна.
- 5.1.43. Чойбалсан хотын дулаан, цэвэр, бохир усны үндсэн болон салбар шугамуудыг хот төлөвлөлттэй уялдуулан үе шаттайгаар өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.1.44. 1990 оноос өмнө баригдсан нийтийн орон сууцны барилгын дотор халаалт, цэвэр, бохир усны шугам хоолойг шинэчлэн солих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.2. ХЭРЛЭН СУМ

5.2.1. Хэрлэн сумын 1 дүгээр баг

- 5.2.1.1. Ерөнхий боловсролын 11 дүгээр сургуулийг өргөтгөн их засвар хийнэ.
- 5.2.1.2. Дулааны шугам сүлжээг шинэчилнэ.
- 5.2.1.3. Силикат, нуур гэр хороололд шинэ цэцэрлэг барина.
- 5.2.1.4. Гэр хорооллын дунд стандартын шаардлага хангасан жишиг тоглоомын талбай байгуулна.
- 5.2.1.5. Гэр хорооллын ундны усны худгийн тоог нэмэгдүүлнэ.
- 5.2.1.6. Хотын төвийн хогийн цэгийг нүүлгэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 5.2.1.7. Бага оврын цэвэрлэх байгууламж байгуулж, 50-р байрны бохир ус зайлуулах системийг шийдвэрлэнэ.
- 5.2.1.8. Гэр хорооллын эгнээ гудамжинд гэрэлтүүлгийн тоо нэмэгдүүлнэ.
- 5.2.1.9. Цэнхэр хорооллын замыг хатуу хучилттай болгоно.
- 5.2.1.10. Хүлэмж хорооллын арын замыг хатуу хучилттай болгоно.
- 5.2.1.11. Зүүн цемент /Ялалт/ гүүрний урд болон хойд хэсгийн замыг хатуу хучилттай болгоно.

5.2.1.12. “ДБЭХС” ТӨХК-ийн баруун талын замыг хатуу хучилттай болгох ажлыг уул уурхай, эрчим хүчний үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

5.2.2. Хэрлэн сумын 2 дугаар баг

- 5.2.2.1. Өрхийн эмнэлгийн салбарыг багийн нутаг дэвсгэрт байгуулах боломжийг судалж шийдвэрлэнэ.
- 5.2.2.2. 2-р цэцэрлэгийг өргөтгөж, салбар бүлгийн гадаа тоглоомын талбайг тохижуулна.
- 5.2.2.3. Шинээр цэцэрлэг барина.
- 5.2.2.4. Хан-Уул цогцолбор сургуулийн гадна спорт талбай байгуулна.
- 5.2.2.5. Хан-Уул цогцолбор сургуулийн дотуур байрыг шинээр барина.
- 5.2.2.6. 2 дугаар багийн спорт заалыг шугам сүлжээнд холбоно.
- 5.2.2.7. Өрхийн аж ахуйг дэмжинэ. /хүлэмж, зоорь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх/
- 5.2.2.8. 2 дугаар багийн урд төв зам дагуу явган хүний зам тавина.
- 5.2.2.9. Тээвэрчдийн гудамжны хойд хэсэгт цахилгааны эх үүсвэр татаж газрын гэрчилгээ авсан иргэдийг өмчлөлийн газарт амьдрах боломжоор хангана.
- 5.2.2.10. Камержуулалт, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 5.2.2.11. Модон гүүрийг цемент бетон гүүр болгох ажлыг эхлүүлнэ.

5.2.3. Хэрлэн сумын 3 дугаар баг

- 5.2.3.1. Шинэ цэцэрлэгийн гадна орчны стандарт тохижилт, хуучин цэцэрлэгийн барилгын гадна засвар хийнэ.
- 5.2.3.2. Хүлэмж төсөл хэрэгжүүлнэ.
- 5.2.3.3. Багийн ажлын албаны байранд их засвар хийнэ.
- 5.2.3.4. Монгол дайчдын хөшөөний урд талын цэцэрлэгт хүрээлэнг Хүүхдийн парк болгоно.
- 5.2.3.5. Овоот, Танк, Бумбат хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 5.2.3.6. Малжуулах төсөл хэрэгжүүлэхийг дэмжинэ.
- 5.2.3.7. Дэнжийн хэсэгт гүний худаг байгуулна.
- 5.2.3.8. Танк, овоотын хэсгийн цахилгааны хүчдэл нэмэгдүүлнэ.
- 5.2.3.9. Овоот, Танк, Дэнж, Бат-Уул, Бумбатын хэсэгт камержуулалттай болгоно.
- 5.2.3.10. Төв замын гэрэлтүүлгийг Танкийн хэсэгт хүргэнэ.
- 5.2.3.11. 1000 айлын орон сууцны хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж тус хороолол руу татсан дэд бүтцийн шугамнаас босоо тэнхлэгийн шугамыг салаалуулан айл өрх албан байгууллагыг холбох боломж бүрдүүлнэ.

5.2.4. Хэрлэн сумын 4 дүгээр баг

- 5.2.4.1. Шинээр баригдаж буй 150 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгаж, төвлөрсөн шугам сүлжээнд холбоно.
- 5.2.4.2. Хэрлэн сумын 4 дүгээр багийн иргэдийн “Чөлөөт цаг”-ийг зөв боловсон өнгөрүүлэх цогцолбор /парк/ талбай байгуулна.
- 5.2.4.3. Дулааны шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. /Загвар Хан-Уул/
- 5.2.4.4. Ахмадын чөлөөт цагийн танхимтай болно.
- 5.2.4.5. Багийн бүх эгнээ гудамжийг гэрэлтүүлэгтэй болгоно.
- 5.2.4.6. Багийн иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хяналтын камержуулалт хийнэ.
- 5.2.4.7. Зангиатын эгнээнд явган хүний зам тавина.
- 5.2.4.8. “Гудамж” төсөл хэрэгжүүлнэ.

5.2.4.9. ТМС-ийн шар байр, багшийн коллежийн 5, 6, 7 дугаар байр, 45, 46 дугаар байрны дээврийн засвар, дулааны болон цэвэр, бохир усны шугамыг засварлана.

5.2.4.10. Гэр хорооллын алслагдсан хэсэг дээр цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дулааны шугамын дэд станц байгуулна.

5.2.5. Хэрлэн сумын 5 дугаар баг

5.2.5.1. Хуучин багийн ажлын албаны байрыг засварлаж, Өрхийн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлнэ.

5.2.5.2. Цэцэрлэгийн барилга байгууламжид өргөтгөл хийж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

5.2.5.3. Хүүхдийн тоглоомын талбай байгуулна.

5.2.5.4. Халуун усны газар барина.

5.2.5.5. Хүлэмж /өвөл, зуны/ төсөл хэрэгжүүлнэ.

5.2.5.6. Багийн ажлын албаны байрыг шинээр барина.

5.2.5.7. Гудамж, хашаа төсөл хэрэгжүүлнэ.

5.2.5.8. Гүний худаг гаргаж хүн малын усан хангамжийг нэмэгдүүлнэ.

5.2.5.9. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ..

5.2.5.10. Ялалт гүүрний урд болон хойд хэсгийн замыг хатуу хучилттай болгох ажлыг эхлүүлнэ.

5.2.5.11. Оргил хорооллын агаарын цахилгаан дамжуулах шугамыг шинээр барина.

5.2.5.12. Өндөр хүчдэлийн шугам татаж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

5.2.6. Хэрлэн сумын 6 дугаар баг

5.2.6.1. Ивээл, Буйр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулна.

5.2.6.2. Ахмадын чөлөөт цаг өнгөрүүлэх танхим байгуулна.

5.2.6.3. Ивээл хороололд дахин төлөвлөлт хийх ажлыг эхлүүлнэ.

5.2.6.4. Буйр хороололд цэвэр усны худаг гаргана.

5.2.6.5. Буйр хорооллын хөрсний бохирдлыг бууруулна.

5.2.6.6. Өнөр 21-р байрны гадна ус зайлуулах хоолой хийнэ.

5.2.6.7. Орон сууцны хорооллын бохирын шугам сүлжээнд засвар хийнэ.

5.2.6.8. Өнөр, Ивээл, Уурхайн хорооллын барилгын дээврийг засварлана.

5.2.6.9. Олон нийтийн цагдаа ажиллуулна.

5.2.6.10. Ивээл, Өнөр, Уурхайн хороололд камержуулалт хийнэ.

5.2.6.11. Явган хүний зам, гэрэлтүүлэг, камержуулалт, авто зогсоолыг нэмэгдүүлнэ.

5.2.7. Хэрлэн сумын 7 дугаар баг

5.2.7.1. Багт шинэ цэцэрлэг барина.

5.2.7.2. Стандартын шаардлага хангасан жишиг тоглоомын талбай байгуулна.

5.2.7.3. Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд чийрэгжүүлэлтийн спорт талбай байгуулна.

5.2.7.4. Ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

5.2.7.5. Орон сууцны байруудын зоорийн давхрын инженерийн шугам сүлжээг шинэчлэн засварлана.

5.2.7.6. Мянгат хорооллын араар камержуулалттай, гэрэлтүүлэг бүхий авто зам, дугуйн зам байгуулна.

5.2.7.7. Орон сууцны байруудад камержуулалт, гэрэлтүүлэг бүхий авто зам, дугуйн зам байгуулна.

5.2.7.8. Ахмадын чөлөөт цагийн төв байгуулна.

5.2.7.9. Орон сууцны ар талд болон газрын дор далд зогсоол, граж байгуулна.

5.2.7.10. Нарлаг хороололд ухаалаг усан сан байгуулна.

5.2.8. Хэрлэн сумын 8 дугаар баг

- 5.2.8.1. Гэр хорооллын дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулна.
- 5.2.8.2. Ахмадуудад зориулж 56, 57, 58 дугаар байрнуудын дунд чийрэгжүүлэлтийн талбай шинээр хийнэ.
- 5.2.8.3. Баялаг хорооллын зүүн талд шинээр гүний худаг эсвэл усан санг байгуулж стандартад нийцүүлэн тохижуулна.
- 5.2.8.4. Тоосгоны үйлдвэрийн хур хогийг булж, газрыг тэгшилнэ.
- 5.2.8.5. Баялаг хороололд гудамжны гэрэлтүүлэг хийнэ.
- 5.2.8.6. Багийн ажлын албаны байрны гадна засвар болон дээврийн бүрэн засвар хийнэ.
- 5.2.8.7. 56, 57, 58 дугаар байрны гадна явган хүний зам, **автомашин, зогсоол,** зүлэгжүүлэлт хийнэ.
- 5.2.8.8. Ахуй үйлчилгээний төв байгуулна.
- 5.2.8.9. Ахмадын чөлөөт цагийн төв байгуулна.
- 5.2.8.10. Цэвэр усны төвлөрсөн шугамыг шинэчилж дуусгана.

2117144066

5.2.9. Хэрлэн сумын 9 дүгээр баг

- 5.2.9.1. 1990 оноос өмнө баригдсан нийтийн орон сууцнууд /1-17 дугаар байр/-ын инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.2.9.2. Орон сууцнуудын орцуудын засвар шинэчлэлийг хийж, гадна хаалгыг кодтой цоожтой болгох, байрнуудын фасадны өнгө үзэмжийг сайжруулах, дулаан алдагдал ихтэй болсон зарим угсармал байрнууд /нэн түрүүнд 1-11 дүгээр байр/-ын цууралт эвдэрлийг засварлаж, гадна ханыг дулаалах ажлыг хэрэгжүүлнэ.
- 5.2.9.3. Орон сууцнуудын гаднах хүүхдийн тоглоомын талбайн тоглоом, чийрэгжүүлэлтийн төхөөрөмжүүдийн хүрэлцээг нэмэгдүүлэх, цэцгийн мандал, ногоон байгууламж, явган хүний зам, гарц, автозам, зогсоолуудыг хотын өнгө үзэмжид тохирсон цогц байдлаар бүрэн шийдвэрлэнэ.
- 5.2.9.4. Дөрвөн байшингийн дундах тоглоомын талбайг бичил цэцэрлэгт хүрээлэн, чийрэгжүүлэлтийн төхөөрөмж бүхий хотын жишиг амралт, тоглоомын талбай болгон тохижуулна.
- 5.2.9.5. Орон сууцны хороолол дунд болон гудамж талбайн камержуулалтыг нэмэгдүүлнэ.
- 5.2.9.6. Орон сууцны байруудын үүдний замыг нэг урсгалтай болгох, авто ослоос сэргийлэх тэмдэг тэмдэглэгээг сайжруулна.
- 5.2.9.7. Орон сууцнуудын дулаан хангамжийг сайжруулах зорилгоор дулааны 2-р сүлжээнд холбох ажлыг ээлж дараатай хэрэгжүүлнэ.

5.2.10. Хэрлэн сумын 10 дугаар баг

- 5.2.10.1. Шинээр цэцэрлэг барьж, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулна.
- 5.2.10.2. Сургуулиас алслагдсан гэр хорооллын сурагчдад үйлчлэх сурагчийн автобустай болгоно.
- 5.2.10.3. Эгнээ гудамжны эмх цэгцийг сайжруулна.
- 5.2.10.4. Багийн ахмадын байр, чөлөөт цагийн төвийн барилгыг шинээр барьж, чийрэгжүүлэлтийн талбай, техник тоног төхөөрөмжөөр хангана.
- 5.2.10.5. Ялалт хорооллын дунд халуун усны газар, ахуй үйлчилгээний цэгтэй болно..

- 5.2.10.6. Нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхүүдэд төмс, хүнсний ногоо тариалахад нь зориулж, хүлэмж байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 5.2.10.7. Мал аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэд, цөөн малтай иргэдийг малжуулах төсөлд хамруулна.
- 5.2.10.8. Ялалт хорооллын 20 дугаар гудамжнаас хойших айл өрхүүдийн дунд ухаалаг үйлчилгээтэй усан сантай болгоно.
- 5.2.10.9. Ялалт хороололд хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барина.
- 5.2.10.10. Ялалт хорооллын зүүн болон баруун талын босоо тэнхлэгийн замуудын 2 талын замыг үерийн усны хамгаалалт, гарцтай болгоно.
- 5.2.10.11. Орон сууцны 26, 49а, б, 90 дүгээр байрны подвальный инженерийн шугам сүлжээ, орон сууцны хоорондын дулаан болон цэвэр, бохир усны шугамыг шинэчилнэ.

5.2.11. Хэрлэн сумын 11 дүгээр баг

- 5.2.11.1. Шинээр цэцэрлэг барина.
- 5.2.11.2. Хивсний 13 дугаар эгнээнд хүүхдийн тоглоомын талбай байгуулна.
- 5.2.11.3. Хивсний 1-р эгнээний Биеийн тамирын талбайг сэргээн тохижуулна.
- 5.2.11.4. Халуун усны газартай болгоно.
- 5.2.11.5. Гэр хорооллын эгнээ гудамжны гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 5.2.11.6. Содномдаржаагийн гудамжны босоо тэнхлэгийн замын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 5.2.11.7. Чойбалсан хотын босоо тэнхлэгийн замын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 5.2.11.8. Алслагдсан гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор цахилгаан дулааны шугам, дэд станц шинээр барина.
- 5.2.11.9. Дулааны шугам сүлжээг өргөтгөнө.
- 5.2.11.10. Шинэ хөгжил цогцолбор сургуулийн өргөтгөл, дээврийн засварын ажлыг хийнэ.

6. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 “Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.1.1 Сумдын эмнэлэгийн эмч, ажилтнуудын ажиллах орчин, нийгмийн асуудлыг сайжруулахад анхаарч тогтвортой ажиллах бололцоог бүрдүүлнэ.
- 6.1.2 Сумын Соёлын төвийг “Хүний хөгжлийн төв” болгон хөгжүүлж соёл урлагийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх, соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 6.1.3 Сум бүрт биеийн тамирын арга зүйч ажиллуулж нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.
- 6.1.4 Сумын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэдэг эмнэлэг, цэцэрлэг, сургууль, дотуур байр, соёлын төвийн барилга байгууламжийг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай эхлүүлнэ.
- 6.1.5 “Залуу малчин” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.1.6 Мал эмнэлгийн тасгуудыг бэхжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган мал сүргийг эрүүлжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.1.7 Нийтийн тээвэр /сумдад стандарт/
- 6.1.8 Малын хулгайтай тэмцэх, хэв журмын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор сумдын цагдаагийн тасаг, хэсгийг тоног төхөөрөмжөөр хангаж унаажуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.1.9 Сумын төвүүдэд халуун усны газрын хүрэлцээг нэмэгдүүлнэ.

- 6.1.10 Бүх суманд "Шинэ усан сан" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.1.11 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, шаардлагатай цэгт инженерийн шийдэлтэй худаг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 6.1.12 Сумын төвийн суурилагдсан хүчин чадлаас давсан толгой дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 6.1.13 Сумдыг стандартад нийцсэн ундны ус цэвэршүүлэх, шүүгч төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллагааг бүрэн хангана.
- 6.1.14 Сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг сэргээн засварлах, өргөтгөх арга хэмжээг үргэлжлүүлэн хийнэ.
- 6.2 Баяндун сум
- 6.2.1 Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцлийг сайжруулна.
- 6.2.2 Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. /Нөхөн сэргээх менежментийг сайжруулах/
- 6.2.3 Бага сургууль барина.
- 6.2.4 Сумын эрүүл мэндийн төвийн засварын ажлыг хийнэ.
- 6.2.5 Сумын ЗДТГ-ын засварыг хийнэ.
- 6.2.6 Сумын төвийн авто замыг сайжруулах ажлыг хийнэ.
- 6.2.7 Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 6.2.8 Шинээр худаг гаргах, засварлах замаар уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.
- 6.2.9 Сумын тариаланд тохиромжтой атар болон атаршсан талбайг эргэлтэд оруулна.
- 6.2.10 Малын дайвар бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийг байгуулна.
- 6.2.11 Мах, ногоо хадгалах зоорь байгуулна.
- 6.2.12 Уламжлалт буриад ахуй, соёлын дахин давтагдашгүй байдлыг алдагдуулахгүй өвлүүлэн үлдээнэ.
- 6.2.13 Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, үйлчилгээний тав тухтай орчинг бүрдүүлнэ.
- 6.3 Баянтүмэн сум
- 6.3.1 Сумын хүн эмнэлгийг /ЭХО аппарат/-тай болгоно.
- 6.3.2 Сургуулийн дотуур байранд их засвар хийнэ.
- 6.3.3 Сургуулийн спорт заалыг шинээр барина.
- 6.3.4 Сумын Засаг даргын Тамгын газрын барилга шинээр барина.
- 6.3.5 Хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйг дэмжинэ.
- 6.3.6 Шаазан нуурын орчимд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, тэжээлийн үйлдвэр барихыг бодлогоор дэмжинэ.
- 6.3.7 Өвсний нөөцийн агуулахыг бүх багт байгуулна.
- 6.3.8 Тахианы аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.3.9 Сумын төвийн 1 км асфальтан хучилттай замыг үргэлжлүүлэн барина.
- 6.3.10 "Хоёр мэлхийт"-ийн нуурыг сэргээх төсөл хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.3.11 Хөдөөгийн багт ундны болон бэлчээрийн худаг, ус байгуулна.
- 6.3.12 Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилнэ.
- 6.3.13 Сумын төвийн хорооллуудын гадна гудамжны гэрэлтүүлэг, цамхагт гэрэл хийнэ.

- 6.4 Баян-Уул сум
- 6.4.1 Сумын Эрүүл мэндийн төвд өргөтгөл, их засвар хийнэ.
- 6.4.2 Шинээр цэцэрлэг барина.
- 6.4.3 Бэрх багийн цэцэрлэгийн барилгад засвар хийнэ.
- 6.4.4 Ерөнхий боловсролын сургуулийн 150 хүүхдийн дотуур байр барина.
- 6.4.5 Спорт заалны барилгад их засвар хийнэ.
- 6.4.6 Хуучин сургуулийн барилгыг засварлаж ашиглана.
- 6.4.7 Хүн ам төвлөрсөн багуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулна.
- 6.4.8 Төрийн албан хаагч, бага орлоготой өрхийг орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.4.9 Хөдөөд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр мах болон малын гаралтай түүхий эдийг боловсруулах цех байгуулна.
- 6.4.10 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, шаардлагатай цэгт инженерийн шийдэлтэй худаг байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 6.4.11 Хүнсний ногоо тариалдаг өрх, иргэдийг бодлогоор дэмжин тариалалтыг нэмэгдүүлж шаардлага хангасан агуулах, зоорины хүртээмж нэмэгдүүлнэ.
- 6.4.12 4, 5 дугаар багт ажлын албаны байр барина.
- 6.4.13 Сум дундын цагдаагийн тасгийн кабоны барилга шинээр барина.
- 6.4.14 Сумын төвд гэрэлтүүлэг, ногоон байгууламж бүхий нийтийн эзэмшлийн тайлбайг байгуулж ахмад настан, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийн орчин бүрдүүлнэ.
- 6.4.15 Сумын төвийн авто замыг асфальтан зам болгох ажлыг үргэлжлүүлэн хийж, борооны ус зайлуулах суваг тавина.
- 6.4.16 Эрчим хүчний шугам сүлжээний толгой дэд станцыг өргөтгөнө.
- 6.4.17 Бохир татан зайлуулах авто машинтай болно
- 6.5 Булган сум
- 6.5.1 Сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл барина.
- 6.5.2 Хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна засвар, бохирын хоолойг шинэчилнэ.
- 6.5.3 Соёлын төвийн барилгыг барьж дуусгана.
- 6.5.4 Ахмадын өргөө байгуулна.
- 6.5.5 Засаг даргын Тамгын газрын барилгад их засвар хийнэ.
- 6.5.6 Тугийн сүмийг барьж дуусгана.
- 6.5.7 Төсөвт байгууллагуудыг төвлөрсөн халаалтын системд холбоно.
- 6.5.8 Сумын төвд "Гудамж" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.6 Гурванзагал сум
- 6.6.1 Сургуулийн барилгад өргөтгөл хийнэ.
- 6.6.2 Залуу гэр бүл, Төрийн албан хаагчид, Олон хүүхэдтэй гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ /15 айл/
- 6.6.3 Төрийн албан хаагч болон амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэдэд малжуулах төсөл хэрэгжүүлнэ.
- 6.6.4 Сумын төвийн нэгдсэн ногооны талбайн усалгааны системийг шийдвэрлэнэ.
- 6.6.5 Алслагдсан бэлчээрүүдийг усжуулах, худаг гаргах ажлыг нэмэгдүүлнэ.
- 6.7 Дашбалбар сум
- 6.7.1 Малын арьс шир боловсруулах цех байгуулахыг дэмжиж ажиллана.
- 6.7.2 Хог дахин боловсруулах жижиг дунд үйлдвэр байгуулна
- 6.7.3 Сумын төвийг халаалтын нэгдсэн байгууламжид холбоно.
- 6.7.4 Сумын төвийн 1,5 км авто замыг иж бүрэн хатуу хучилттай зам болгох
- 6.7.5 Замын хажуу талаар дугуйн зам болон явган хүний стандартын зам хийнэ.

- 6.7.6 Замын хажуу талаар жижиг хашаа хийн мод тарьж гэрэлтүүлэг хийж цогц хэлбэрээр шийдвэрлэнэ.
- 6.7.7 Сумын төвийн цахилгаан дамжуулах шугамыг 35 кв болгон өргөтгөнө.
- 6.8 Сэргэлэн сум
- 6.8.1 Эрүүл мэндийн төвийн барилгын дээвэр, гадна засвар, автомашины парк шинэчлэлт, цогцос хадгалах хөргөгчтэй болгоно.
- 6.8.2 150 хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгыг ашиглалтад оруулна
- 6.8.3 Соёлын төвд засвар хийнэ
- 6.8.4 Сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна
- 6.8.5 Цэцэрлэгийн хуучин барилгыг засварлаж, төрийн албан хаагчдын орон сууц болгоно.
- 6.8.6 Суманд мал нядалгааны нэгдсэн цэгтэй болно.
- 6.8.7 Сумын төвд ундны ус цэвэршүүлэх иж бүрэн байгууламжтай болно.
- 6.8.8 Сумын төвийг нэгдсэн дулаан хангамжтай болгох ажлыг эхлүүлнэ.
- 6.8.9 Суманд аялал жуулчлалын бааз байгуулах санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.9 Матад сум
- 6.9.1 Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барина.
- 6.9.2 Шинээр цэцэрлэг барина.
- 6.9.3 ЕБС-ийн Спорт заалны засвар хийнэ.
- 6.9.4 Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл хийнэ.
- 6.9.5 Нутгийн удирдлагын ордны барилга барина.
- 6.9.6 Сумын төвийн автозам тавина.
- 6.9.7 Сумын төвийг нэгдсэн халаалтад холбох ажлыг эхлүүлнэ.
- 6.10 Халхгол сум
- 6.10.1 Сумын Эрүүл мэндийн төвийг Эхо аппараттай болгоно.
- 6.10.2 Сумын орон сууцны барилгуудыг инженерийн шугамд бүрэн холбоно.
- 6.10.3 Сумын үерийн нэгдсэн далан байгууламжийг сэргээн засварлана.
- 6.10.4 Хамар давааны зам засварлана.
- 6.10.5 Хуучин сумыг Шинэ сумтай холбох 300 м хатуу хучилттай зам барих, гэрэлтүүлэг явган хүний замтай болох ажлыг шийдвэрлэнэ.
- 6.10.6 Баянхошуу боомтоос Газрын тосны 21 дүгээр талбай хүртэлх замыг барьж дуусган ашиглалтад оруулна.
- 6.10.7 Ургамлын бүтэц, судалгаа хийх.
- 6.10.8 Сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгоход орон нутгаас дэмжинэ.
- 6.10.9 Их бурхант цогцолборыг сэргээн засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 6.10.10 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
- 6.10.11 Буйр нуурын загасны аж ахуй
- 6.10.12 Мухар улаан үхэрийг эрчимжсэн аж ахуй хэлбэрээр өсгөхөд дэмжлэг үзүүлнэ.
- 6.10.13 Хүүхдийн овоо, Их бурхант цогцолборыг түшиглэсэн "Буйр" усан аялал жуулчлалыг хөгжүүлэх
- 6.10.14 Халхголд ялалтын цогцолбор байгуулна.
- 6.11 Хөлөнбуйр сум
- 6.11.1 Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барина.
- 6.11.2 Хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барина.

- 6.11.3 Ерөнхий боловсролын сургуулийн А, Б байрны хүзүүвчний засвар хийнэ.
- 6.11.4 Соёлын төвийн их засвар, халаалтын систем шинээр тавина.
- 6.11.5 Ахмадын хорооны байрны өргөтгөл барина.
- 6.11.6 Сумын Засаг даргын Тамгын газрын байр шинээр барина.
- 6.11.7 Сумын төв дундуур 2.1 км урттай засмал зам тавих ажлыг эхлүүлнэ.
- 6.11.8 Цагдаагийн кабоны өргөтгөлийн барилгын асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.11.9 Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.12 Цагаан-Овоо сум
- 6.12.1 320 хүүхдийн Бага сургуулийн барилга шинээр барина.
- 6.12.2 Цэцэрлэгийн өргөтгөл шинээр барина.
- 6.12.3 Орон нутаг судлалын танхимыг их засварт оруулж байнгын үйл ажиллагаатай болгоно.
- 6.12.4 Нутгийн удирдлагын ордны их засвар хийнэ.
- 6.12.5 Орлого багатай өрхийг хямд өртгөөр орон сууцжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 6.12.6 Малжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.12.7 Багуудыг нар, салхины эрчим хүчний эх үүсвэртэй болгоно.
- 6.12.8 Сумын төв доторх замыг сайжруулж тэмдэгжүүлэх ажлыг хийнэ.
- 6.12.9 Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 6.12.10 Нэгдсэн халаалтын систем байгуулж төрийн байгууллага болон аж ахуйн нэгж айл өрхүүдийг холбох ажлыг эхлүүлнэ.
- 6.12.11 Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвлийн хүлэмж байгуулна.
- 6.12.12 Гүнцэнгэлэг амралтыг аялал жуулчлалын чиглэлээр тохижуулж, 11.5 км урт ЦДАШ барина.
- 6.13 Чойбалсан сум
- 6.13.1 Эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөл хийж засварлана.
- 6.13.2 Хуучин сургуулийн байрыг засварлаж ахуйн үйлчилгээний төв байгуулна.
- 6.13.3 Биеийн тамир спортын заал барина.
- 6.13.4 Монгол улсын хошой баатар маршал Х.Чойбалсангийн мэндэлсэн газар хүндэтгэлийн цогцолбор барина.
- 6.13.5 Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны инженерийн байгууламж барина.
- 6.13.6 Иргэдийг хямд, орчин үеийн шийдэл бүхий орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.13.7 Сумын төвд нийтийн ариун цэврийн байгууламж барина.
- 6.13.8 Хөх нуур, Сүмийн цагаан нуурт аялал жуулчлалын бүс, баазууд байгуулна.
- 6.13.9 Хавирга хилийн боомтын үйлчилгээний газруудад ариун цэврийн байгууламж барина.
- 6.13.10 Аймаг болон Чойбалсан хот, Хавирга хилийн боомттой хатуу хучилттай авто замаар холбогдоно.
- 6.13.11 Сумын төвийн өрхүүдэд "Жишиг гудамж" төсөл хэрэгжүүлнэ.
- 6.13.12 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхийг дэмжинэ.
- 6.14 Чулуунхороот сум
- 6.14.1 Зүүн Эрээнцавд 50 ортой хүүхдийн цэцэрлэг барина.
- 6.14.2 Залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулна.
- 6.14.3 Сумын төвд "Орон нутгийг судлах музей"-н барилга барих ажлыг судална.
- 6.14.4 Сумын төвд ахуй үйлчилгээний төв барина.
- 6.14.5 Монгол дагуурын Дархан цаазат газрыг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулна.
- 6.14.6 Улз гол дээгүүр 100м урттай төмөр бетон гүүр барих ажлыг эхлүүлнэ.

6.14.7 Нэгдсэн халаалтын систем байгуулж төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, айл өрхүүдийг холбох ажлыг эхлүүлнэ.

ДОРНОД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

